

АСЕАН-Ы ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ МОНГОЛ УЛСЫН БАЙР СУУРЬ, ОЙРТОЖ ТҮНШЛЭХ ШААРДЛАГА БА БОЛОМЖИТ ГАРЦ

*Б.Цэнгэлхам**

Энэхүү өгүүллээрээ манай улс АСЕАН буюу Зүүн Өмнөд Азийн Улсуудын Холбооны талаар баримталж буй байр суурь, харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх шаардлага, боломжит гарц бий эсэх талаар тодруулж гаргахыг зорилоо.

1. Монгол Улс, АСЕАН-ы гишүүн орнуудын харилцааны өнөөгийн төрх

Монгол Улс АСЕАН-ы бүх гишүүн орнуудтай дипломат харилцаатай ба зарим орнуудтай уламжлалт, найрсаг харилцаатай явж ирсэн. Уламжлалт харилцааны хөрс суурийг бэхжүүлэхийн сацуу АСЕАН-ны бусад гишүүн орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, ялангуяа эдийн засаг, худалдааны салбарт урагшлуулахад Монгол Улс анхаарч ажиллаж байна.

1987 онд АСЕАН-ы гишүүн орнуудын Дээд хэмжээний уулзалтад манай Засгийн газар илгээлт явуулж, байгууллагатай харилцаа тогтоох анхны алхам хийсэн.²

Монгол Улс нь АСЕАН-ы гишүүн орнуудтай хоёр талын харилцаагаа тасралтгүй бэхжүүлж ирэв. Зүүн Азийн бүс нутгийн олон талт хамтын ажиллагааны бүтцүүдэд Монгол Улс нэгдэх аятай нөхцлийг бүрдүүлэх, тэргүүн ээлжинд АСЕАН-ы Найрамдал, хамтын ажиллагааны гэрээнд нэгдэж орох, Зүүн Азийн хамтын нийгэмлэг байгуулах үйл явцад эхнээс нь оролцох зорилтыг хангахад АСЕАН-ы гишүүн орнуудын дэмжлэг авах, тэдгээртэй хоёр талын харилцааг өргөжүүлэх зорилт тавьж ажиллан 2005 онд зарим үр дүнд хүрлээ.³

Тухайлбал, Монгол Улс АСЕАН-ы Найрамдал, хамтын ажиллагааны гэрээнд 2005 оны 7-р сард нэгдэн орж чадсан бөгөөд уг гэрээг УИХ мөн сард соёрхон баталжээ. Цаашид бүс нутгийн орнуудтай худалдаа, эдийн засгийн өргөн харилцаа хөгжүүлэх, АСЕАН-ы орнуудтай яриа хэлэлцээний механизм тогтоох зэрэг шаардлагыг хангах чиглэлээр ажиллаж байна.

Сүүлийн үед Монгол Улсын төрийн дээд албан тушаалтнуудын АСЕАН-ы гишүүн орнуудад хийсэн айлчлалаас дурьдвал, Монгол Улсын Ерөнхийлөгч 1994 онд БНСВУ, БНАЛАУ, Тайландад, 1997 онд Индонезид, 2000 онд Филиппинд, 2001 онд Сингапурт, 2005 онд

* Б.Цэнгэлхам - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

БНСВУ, БНАЛАУ-д төрийн айлчлал, Монгол Улсын Ерөнхий сайд 1995 онд Сингапур, Малайзад, 2002 онд Индонези, Сингапур, БНСВУ-д, 2005 онд Тайландад тус тус албан ёсны айлчлал хийсэн бол хариуд нь 1997 онд Малайзын Ерөнхий сайд, 1999, 2004 онд БНСВУ-ын Ерөнхий сайд, 2000 онд БНСВУ-ын Ерөнхийлөгч, БНАЛАУ-ын Үндэсний Ассемблейн дарга, 2003 онд Индонезийн Ерөнхийлөгч, Тайланд Вьетнамын Их Хурлын дарга нар, 2007 онд БНАЛАУ-ын Ерөнхийлөгч, 2008 онд БНСВУ-ын Ерөнхийлөгч тус тус Монгол Улсад айлчлав.

АСЕАН-ы гишүүн зарим орнуудтай тогтоосон хоёр талын харилцаанд ахиц гарсан бөгөөд олон талт хамтын ажиллагааны хүрээнд дэмжлэг авч ажиллах чиглэлд ахицтай байлаа. АСЕАН-ы гишүүн орнуудын ерөнхий үзүүлэлтүүдийг *хүснэгт 1*-ээс үзэж болно.

АСЕАН-ы орнуудтай хийж буй худалдаа, хөрөнгө оруулалт бага боловч нэмэгдэж байгаа ч дорвитой өсөхгүй байна. /*Хүснэгт 2-оос үз.* 2008 оны байдлаар Вьетнамтай хийсэн худалдаа 10.5 сая, Лаостай 150 мянга, Сингапуртай 45 сая, Тайландтай 17.2 сая, Малайзитай 26 сая, Индонезитэй 7.5 сая, Филиппинтэй 1,1 сая доллар, Камбожитай 378 мянган ам.доллар болжээ.

2. АСЕАН-ны талаар баримталж буй Монгол Улсын байр суурь

Даяаршил, бүс нутгийн интеграцийн үйл явц өрнөж буй өнөөгийн нөхцөлд Монгол Улс Ази, Номхон далайн бүс нутаг руу илүү анхаарч, энэ бүсийн хамтын ажиллагаанд түлхүү оролцох чиглэлийг барьж байна.

Хэдхэн жилийн өмнө Монгол Улс Зөвлөлт-Хятадын харилцааны “барьцааны улс” мэт, газар зүйн хувьд Азийн орон атлаа улс төр, эдийн засаг зэрэг бараг бүх харилцаа нь ЭЗХТЗ-ийн хүрээнд ЗХУ, Зүүн Европтой холбогдсон орон байлаа. Тэгвэл өнөөдөр Монгол Улс ХХ зууны түүхэнд анх удаа хоёр хөршийн харилцааны хүрээнээс ангижран гарч, дэлхийн хамтын нийгэмлэгийн бүх орнуудтай чөлөөтэй харилцах, Азийн орныхоо статусыг эргэн сэргээх бололцоотой болоод байна.⁴ Ийм ч учраас манай гадаад бодлогын тэргүүлэх чиглэлүүдэд тодорхой өөрчлөлтүүдийг хийж, бид Зүүн Азийн Хамтын нийгэмлэг буюу Зүүн Азийн Холбоонд нэгдэх, хамтран ажиллах нөхцөл бололцоог судлахад анхаарлаа хандуулж байна.

1994 онд батлагдсан манай улсын гадаад бодлогын үзэл баримтлалд: “Монгол Улсын гадаад бодлогын гурав дахь чиглэл бол Азийн бүс нутагт байр сууриа батагтаж эндхийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох явдал мөн.... Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага /АПЕК/-д элсэн орохыг зорино. Бүс нутгийн интеграцид орох нөхцлийг юуны өмнө түүнд хамаарч буй улс орнуудтай

хоёр талын харилцааг өргөтгөн хөгжүүлэх замаар бүрдүүлнэ”⁵ хэмээн заасан байдаг. Энэ чиглэлийн дагуу манай улс Ази, Номхон далайн бүс нутаг, Зүүн Азийн Холбоо буюу Хамтын нийгэмлэг рүү анхаарлаа хандуулах шаардлага зүй ёсоор урган гарч байна. Урьд нь Зүүн хойд Ази гэж ярьж байсан бол АСЕАН+3 механизм бий болсноос хойш Зүүн Азийн хамтын нийгэмлэг гэдэг нэр томъёо олон улсын харилцаанд гарч ирээд байна. Ази, Номхон далай дахь Монгол Улсын бодлого нь аюулгүй байдлын олон тулгуурт тогтолцоог бүрдүүлэхэд оршино.⁶

Зүүн Азийн Хамтын нийгэмлэг нь АСЕАН дээр төвлөрсөн бүтэц учир АСЕАН-тай харьцах харилцаагаа хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Дэлхийн эдийн засгийн интеграцлал ХХ зууны хоёрдугаар хагасаас хүчтэй өрнөж, нийтлэг зах зээлийн үндэс тавигдаж, үндэсний эдийн засаг нөгөөтэйгээ улам бүр ойртох болов. Эдүгээ интеграцчилагдсан байгууллагуудын тоо дэлхийн хэмжээнд өссөөр байна. Эдгээр нь эдийн засгийн хийгээд улс төрийн бодит суурь баазтай болсон ажээ. Үүнд, Европын Холбоо, АСЕАН, НАФТА-г нэрлэж болно.⁷

Одоохондоо АСЕАН-ы гишүүн орнууд Зүүн Азийн хамтын ажиллагааны бүсийг бүрэн утгаар нь бий болгох эрмэлзлэлтэй боловч хөгжлийн түвшин ижил биш учраас зарим болгоомжлол байсаар байна. Тухайлбал, АСЕАН+3 гэсэн бүтцийг тодорхой хугацаанд хадгалах нь чухал хэмээн Малайзын Засгийн газар үзэж байна. Учир нь АСЕАН-ы 10 орон тус тусдаа энэхүү хамтын ажиллагаанд оролцвол Хятад, Япон мэтийн том эдийн засгуудтай өрсөлдөх боломж хомс юм. Нөгөө талаас АСЕАН хэмээх байгууллагын үүрэг, байр суурь үгүй болж, АСЕАН-ы орнуудын эрх ашигт хохирол учрах талтай хэмээн болгоомжилж байна. Иймд юуны өмнө АСЕАН-ыг эдийн засгийн хувьд бэхжүүлж байж сая Япон, Хятад, БНСУ-тай бүрэн интеграцид орох бодолтой байна.

Зүүн Азийн шинэ регионализм нь эдийн засгийн өрсөлдөөнд байр сууриа бэхжүүлэх зорилготой тухайн орнуудын хүсэл эрмэлзлэлийн илэрхийлэл юм. Харин улс төр аюулгүйн салбарт энэ бүсийн хамтын ажиллагаа ирээдүй багатай юм хэмээн судлаачид үзэж байна. Учир нь орон тус бүрийн улс төр, аюулгүйн бодлого өөр бөгөөд харилцан ойлголцож зохицоход тодорхой цаг хугацаа шаардлагатай. Улс орон бүр өөрийн үндэсний аюулгүй байдал, төрийн бүрэн эрхээ хадгалан бэхжүүлэх зорилгын үүднээс их гүрнүүдтэй харилцах төрийн бодлого нь ижил биш, олон улсын асуудалд өөр өөр байр сууринаас ханддаг. Эдүгээ энэ талаар нийтлэг нэг байр суурьтай болох орчин нөхцөл хараахан бүрдээгүй байна. Энэ нь олон улсын дэг журам төдийлөн цэгцрээгүй, их гүрнүүдийн ашиг сонирхлын тэнцвэр Ази, Номхон далайн бүс нутагт хараахан тогтворжоогүй байгаатай холбоотой нарийн төвөгтэй үйл явц юм.

Зүүн Азийн эдийн засгийн интеграцчилал хэрэгжихэд зарим бэрхшээл бий.

1. Юуны өмнө тус бүсийн орнуудын эдийн засгийн хөгжлийн түвшин харилцан адилгүй, зарим нь зах зээлийн эдийн засаг хөгжсөн, зарим нь төвлөрсөн эдийн засгаас зах зээлд шилжих шатанд яваа. Гэтэл зарим нь таваарын аж ахуйн дөнгөж хөгжүүлж буй бөгөөд эдийн засгийн хувьд өөрөө өөрийгөө аргацаах төдий түвшинд байна. Энэ нь тус бүсийн эдийн засгийн интеграцчилалд тодорхой цаг хугацааг шаардах хүчин зүйл болж байна.

2. Энэ бүсийн орнуудын ихэнх нь хөгжиж буй орнууд учраас хөрөнгө оруулалт, зээл тусламж, худалдаа, технологи экспорт зэрэг олон салбарт бие биенээс өрсөх хандлагатай. Мөн зарим салбарын үйлдвэрлэл нэн ижил төстэй учраас зах зээлийн өрсөлдөөнд бие биендээ аюул учруулж буй. Тухайлбал, цахилгаан болон электрон барааны үйлдвэрлэл Хятадад нэн эрчимтэй хөгжиж эхэлмэгц Малайз, Тайланд, Филиппин зэрэг орны ижил төрлийн үйлдвэрлэлд аюул учирч болзошгүй болсон гэх мэт.

Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнууд “Хүйтэн дайн”-ы дараа олон улсын харилцаанд гарсан нааштай хандлагуудыг лавшруулан тус бүс нутагт аюулгүй байдлыг төлөвшүүлэх, улс хоорондын харилцаанд итгэлцлийг бэхжүүлэх, энэ чиглэлээр хамтын ажиллагаа идэвхжүүлэх талаар зохион байгуулалттай үйл өрнүүлэхийг эрмэлзэж байсан ба бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар яриа хэлэлцээ явуулах олон талт механизмыг бүрдүүлэх зорилгоор Засгийн газрын хэмжээнд байгуулагдсан анхны байгууллага нь АСЕАН-ны Бүсийн Чуулган юм.⁸

Монгол Улс 1998 онд АСЕАН-ны Бүсийн Чуулган буюу АРФ-д гишүүнээр элссэн ба Монгол Улсын хувьд АРФ нь⁹:

❖ *Нэмэгдэл бололцоо*: Бүс нутгийн аюулгүй байдлын олон талт яриа хэлэлцээнд нэгдэн орох нь хоёр талын болон олон улсын механизмын зэрэгцээ Монгол Улсын аюулгүй байдлыг сахин хамгаалах нэмэгдэл бололцоо олгоно.

❖ *Манай өөрийн бүс нутгийн аюулгүй байдлыг хэлэлцэх нэг суваг*: Зүүн хойд Азийн салбар бүс нутагт аюулгүй байдлын албан ёсны суваг бүрэлдэн хөгжөөгүй нөхцөлд энэ салбар бүс нутгийн аюулгүй байдлыг хэлэлцэх нэгэн чухал суваг болно.

❖ *Институционал холболт*: АРФ-д нэгдсэнээр Монгол Улсын бүс нутаг дахь улс төрийн изоляцийг гэтлэн давах, манай улсыг Ази, Номхон далайн бүс нутагтай холбох нэгэн институционал суваг, бүс нутаг дахь түнш холбоотны тоог нэмэгдүүлэх бололцоо, стратегийн хамтын нийгэмлэгийн бүрэлдэхүүн хэсэг болох бололцоог нээж өгч байна.

❖ *Тогтвортой байдлыг хангах механизм*: Ашиг сонирхлын ялгаа бүхий орнуудыг нэгтгэсэн үйл явц болохынхоо хувьд АРФ нь олон

талт хүчин чармайлтаар тогтвортой байдлыг сахин хамгаалах нэгэн механизм мөн.

❖ *Аюулгүй байдлын төсөөллүүдийг мэдрэх суваг:* Үе шатлалыг эрхэмлэсэн АРФ-ын аядуу хандлагыг аюулгүй байдлын тодорхой бус өнөөгийн орчинд аюулгүй байдлын асуудлаарх улс орнуудын төсөөллүүдийг илүү сайн мэдрэх бололцоо олгох суваг юм.

❖ *Бүс нутгийн олон талт контекст нь хамтын ажиллагааг эрхэмлэсэн гадаад бодлогын соёл төлөвшихөд тулхэц өгөх нэгэн боломж:* Монгол Улс нь НҮБ зэрэг олон улсын байгууллагын хүрээнд аюулгүй байдлын асуудлаар туршлага хуримтлуулсан орон юм. Харин АРФ-ын хэлбэр нь Монгол Улсын хувьд нэгэн шинэ хэлбэр юм. Монгол Улс АРФ-ын хүрээнд ажиллахдаа зөвшилцөл, хамтын ажиллагааг эрхэмлэсэн гадаад бодлого, үйл ажиллагааны туршлагыг бүрдүүлэх учиртай.

❖ *Харилцан нөхөх механизм:* Өнөөгийн шатанд АРФ-ын олон талт үйл явц нь аюулгүй байдлын хоёр талт тохиролцоонуудыг орлохгүй, гагцхүү тэдгээрийг нөхөх механизм юм. Аюулгүй байдлын асуудлаарх хоёр талын яриа хэлэлцээ, зөвлөлдөөнүүд нь олон талт үйл явцад түшиг болно гэж үзнэ.

❖ *Мөргөлдөөнийг шийдвэрлэх чадавхи:* АРФ-ын үйл явц хэтдээ мөргөлдөөнийг шийдвэрлэх бүс нутгийн нэгэн механизм хэлбэрээр хөгжихийг дэмжинэ. Харин ийм чиглэлээр хөгжих хөрс суурь үүсэж чадах эсэхийг оролцооны явцад тодорхойлох ба өнөөгийн шатанд шат дарааллыг эрхэмлэсэн аядуу хандлагыг дэмжиж, бүс нутгийн хэмжээнд мөргөлдөөнөөс зайлсхийх, маргааныг хүч үл хэрэглэн, энхийн аргаар зохицуулахад чиглэгдсэн норм хөгжүүлэн төлөвшүүлэхэд хүчин зүтгэнэ.

АРФ-ын хүрээнд итгэлцлийг бэхжүүлэх, АРФ-ын даргын үүрэг ролийг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх дипломат үйл ажиллагааны үзэл баримтлал, зарчмуудыг хэлэлцэн батлахад, Монгол Улсын аюулгүй байдал, гадаад бодлогын чиглэлийг бүс нутгийн улс орнуудад таниулах, тэдгээрийг урагшлуулахын төлөө Монгол Улс ажиллаж байна. Тухайлбал, “Монгол Улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус”-ын тухай НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолыг дэмжсэн заалтыг АРФ-ын Сайд нарын уулзалтын даргын мэдэгдэлд 4 удаа /1999-2002/ тусгасан.¹⁰

Монгол Улсад 1990-ээд оноос эхэлсэн улс төр, нийгэм, эдийн засгийн шинэчлэл, өөрчлөлттэй уялдан манай орны аюулгүй байдал, гадаад бодлогын чиглэл, зорилт өөрчлөгдөх шаардлага урган гарч ирсэн бөгөөд гадаад бодлогын шинэ зорилтуудад Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудтай харилцах харилцаа, бүс нутгийн хамтын ажиллагааны бүтцүүдэд байр сууриа олох, бэхжүүлэх асуудал тэргүүлэх чиглэлүүдийн нэг болж тодорхойлогдсон билээ.

АСЕАН+3 үйл явцын талаарх Монгол Улсын байр суурь:¹¹

▪ Бүс нутгийн эрчимтэй хөгжиж байгаа энэхүү хамтын ажиллагааг бүх талаар дэмжиж, хамтран ажиллахад бэлэн байна. Учир нь бүс нутгийн байршил, хоёр талын хамтын ажиллагааны байдал, Монголд хандивлагч орнуудын оролцоог авч үзвэл Монгол Улс АСЕАН+3 механизмын гадна үлдэх учиргүй.

▪ 1997 онд бүс нутгийн орнуудын эдийн засагт хүчтэй нөлөөлсөн Азийн санхүүгийн хямралын дараа шинэ хямралаас сэрэмжлэх үүднээс бүс нутгийн орнуудын эдийн засгийн болон санхүүгийн хамтын ажиллагаагаа уялдуулан зохицуулж байгааг Монгол Улс бүрэн дэмжиж байна.

Цаашдаа Монгол Улс Зүүн Азийн эдийн засгийн нэгдсэн орон зайд хамрагдах, улмаар АПЕК-т элсэхэд АСЕАН+3 механизм томоохон дэмжлэг болно гэж үзэж байна.

3. Монгол Улс АСЕАН-тай ойртож түншлэх шаардлага

Түүхээс үзвэл хоёр хөршийн “хайчин бодлогоос”¹² сэрэмжлэн ХХ зууны эхээр барууны томоохон орнуудад хандан, Чин ван Ханддорж тэргүүтэй Монголын төрийн зүтгэлтнүүд туслалцаа хүссэн захиаг илгээж байсан боловч тухайн үед цаг нь болоогүй, нөхцөл нь ч бүрдээгүй байжээ. Хоёрхон том хөрштэй манай орны хувьд аль нэгнийх нь нөлөөнд орохгүйн тулд *олон тулгуурт* гадаад бодлого баримтлах зайлшгүй шаардлагатай болсон байдаг. Иймээс тухайн үеийн гадаад бодлогын шийдвэр гаргагчид гадаад бодлогынхоо амин зорилго болох өөрийн орны тусгаар тогтнолоо хүчтэй улсын “дагуул улс” байдлаар хамгаалахаас өөр аргагүйд хүрчээ.

АСЕАН бол Азийн томоохон байгууллага тул манай улс тус байгууллагын гишүүн улсуудтай дотно харилцаа тогтоож байж сая Ази, Номхон далайн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох боломж буй болно.

Нөгөөтэйгүүр 1994 оны Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд: “Монгол Улсын гадаад бодлогын гурав дахь чиглэл бол Азийн бүс нутагт байр сууриа бататгаж эндхийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох явдал мөн.... Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага /АПЕК/-д элсэн орохыг зорино. Бүс нутгийн интеграцид орох нөхцлийг юуны өмнө түүнд хамаарч буй улс орнуудтай хоёр талын харилцааг өргөтгөн хөгжүүлэх замаар бүрдүүлнэ”¹³ гэж зааж өгсөн бөгөөд энэхүү АПЕК-т гишүүнчлэх асуудалд хоёр талын болон олон талт хэлбэрээр АСЕАН-ы гишүүн орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх замаар дам таатай орчинг бий болгох бүрэн үндэстэй юм. АСЕАН-ы гишүүн 10 орны Лаос, Камбож, Мьянмараас бусад 7 улс нь АПЕК-ын гишүүд бөгөөд бас ч гишүүд дотроо нилээд нэр хүндтэйд тооцогддог юм.

Манай орон АСЕАН-ы найрамдал хамтын ажиллагааны гэрээнд 2005 оны 7-р сард элсээд байна. Манай улс АСЕАН-ы Найрамдал, хамтын ажиллагааны гэрээнд нэгдэн орсноор цаашдаа АСЕАН-ы яриа хэлэлцээрийн түнш болох зорилт¹⁴ тавьж байна.

Монгол Улс хөгжлийн шинэ шатанд гарахын тулд хоёр хөрштэйгөө харилцаагаа улам бүр ашигтай хөгжүүлэхээс гадна гурав дахь хөрш буюу түншлэгчээ зөв сонгох явдал туйлын чухал болно.¹⁵

Ийнхүү хоёр хөршөөс гадна Япон, БНАСАУ, БНСУ зэрэг улсууд, өрнө зүгт Европын Холбооны улсууд, АНУ, Канад, АСЕАН-ны орнууд хийгээд Австрали, Шинэ Зеланд ч манай шинэ гадаад орчныг бүрдүүлэх болов. Эл байдлаас үүдэн манай гадаад харилцаа зөвхөн ОХУ хийгээд Хятадын босоо тэнхлэгээр бус мөн өрнө зүгт Европын Холбоо, уламжлалт харилцаатай Төв хийгээд Дорнод Европын орнууд, дорно зүгт Япон, БНАСАУ, БНСУ, АНУ, Канад, АСЕАН-ы улсууд гэх мэтийг багтаасан Ази, Номхон далайг хамран үргэлжлэх хэвтээ тэнхлэгээр хөгжих болсон.¹⁶

Манай улс АСЕАН-ы орнуудтай хоёр талын харилцаа зарим талаар нилээд ахицтай байлаа. Ялангуяа АСЕМ-д элсэхэд дэмжлэг авах зорилт амжилттай хэрэгжлээ.¹⁷

АРФ нь Ази, Номхон далайн 27 улс орныг /Австрали, Бангладеш, Бруней, Камбож, Канад, Хятад, Европын Холбоо, Энэтхэг, Индонези, Япон, Хойд Солонгос, Өмнөд Солонгос, Лаос, Малайз, Бирм, Монгол, Шинэ Зеланд, Пакистан, Папуа Шинэ Гвиней, Филиппин, Орос, Сингапур, Шриланк, Тайланд, Зүүн Тимор, Америк, Вьетнам/¹⁸ эгнээндээ нэгтгэсэн, бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх зорилготой олон талт яриа хэлцээний үйл явц бөгөөд манай улс 1998 оноос үйл ажиллагаанд нь оролцож ирэв.¹⁹

2005 онд Улаанбаатар хотод зохиогдсон “АРФ-ын орнуудын аюулгүй байдлын үзэл баримтлалд гарч буй өөрчлөлт” семинар нь АРФ-д элссэнээс хойш манай улс өөртөө хүлээн авч явуулсан чухал арга хэмжээ болсон.²⁰ 2007 оны 10-р сарын 31-нээс 11-р сарын 2-нд Бруней улсын нийслэл Бандар Сери Бегаван хотноо болсон АРФ-ын чуулган хоорондын ажлын хэсгийн ээлжит уулзалтад манай төлөөлөгч оролцож, Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын зарим асуудал, тухайлбал Зүүн Хойд Азийн аюулгүй байдлын талаарх Монгол Улсын байр суурийг илэрхийлэв. Түүнчлэн аюулгүй байдлын уламжлалт бус асуудлууд, тухайлбал хүн худалдаалах, мансууруулах бодисын наймаатай тэмцэх, оншгой байдлаас авран хамгаалах чадавхиа бэхжүүлэх чиглэлээр манай улсад авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлж, эдгээр чиглэлд Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай тогтоосон хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх сонирхолтойгоо илэрхийлсэн билээ.²¹

Эдийн засаг нь эрчимтэй өсөн нэмэгдэж байгаа АСЕАН-ы гишүүн эдгээр 10 оронтой хоёр талын хамтын ажиллагааг, ялангуяа эдийн

засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхаарч ажиллавал манай орны зах зээлд БНХАУ-ын ноёрхол тогтохоос сэргийлэхэд тус дөхөм болно гэж үзэж байна. Учир нь бидний өдөр тутмын хүнсний хэрэглээний нэг болох цагаан будаа, төрөл бүрийн хүнсний ногоо, далайн бүтээгдэхүүнүүдийг АСЕАН-ы гишүүн, дэлхийн зах зээлд цагаан будааны экспортоороо нэг, хоёрдугаар байранд ордог Вьетнам, Тайланд зэрэг орнуудаас хагас боловсруулсан болон бэлэн байдлаар нь өөрийн оронд хямд өртгөөр нийлүүлэх бүрэн боломж харагдаж байна. Ингэхийн тулд тээвэрлэлт, төмөр зам, хил гаалийн болон татварын асуудал дээр манай орон БНХАУ, БНСВУ-тай хоёр, гурван талын хэлэлцээр хийх нь зүйтэй.

АСЕАН-тай албан ёсны харилцаа тогтоон хамтарч ажиллах, ингэснээр өөрийн орны эдийн засаг, улс төрийн харилцаанд эерэг чиг хандлагыг бий болгохын тулд манай улс АПЕК-т элсэхийг зорин ажиллаж байгаа энэ үед АСЕАН-ыг гуравдагч хөрш гэж үзэж албан ёсны харилцаагаа нилээд өргөжүүлэхийн зэрэгцээ тус байгууллагын гишүүн орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, улмаар манай улс АПЕК-т элсэхэд тэдгээрийн АСЕАН-ы гишүүн орнуудын дэмжлэгийг олж авах нь бидний гол зорилго юм.

Ази, Номхон далайн бүс нутагт байгаа улс төр, эдийн засгийн хамгийн том бүлэглэл болох АСЕАН, түүний гишүүн орнуудтай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх нь манай улсын гадаад бодлогын үндсэн чиглэлүүдийн нэг яах аргагүй мөн.

Манай улс АСЕАН-ы гишүүн зарим орнуудтай өмнөх тогтолцооны үеэс ойр дотно харилцаатай явж ирсэн бөгөөд АСЕАН-тай хамтран ажиллах шаардлагыг дараах байдлаар тайлбарлаж болно. Үүнд:

➤ Ази, Номхон далайн бүс нутгийн улс орон хэмээн өөрийгөө тодорхойлж буй Монгол Улс эл бүс нутаг дахь улс төр, эдийн засгийн хамгийн том бүлэглэлтэй ойр дөт харилцаатай байх нь зүй ёсны шаардлага,

➤ Тогтвортой, аюулгүй Зүүн Ази бол Монгол Улсын ашиг сонирхол бөгөөд ийм ч учраас Зүүн Азийн орнуудтай АСЕАН-ы хөгжүүлж буй хамтын ажиллагаа, бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаарх яриа хэлцээний олон талт үйл явц болох АРФ-д Монгол Улсын оролцоог хангаж, ашиг сонирхлыг урагшлуулах,

➤ Эдийн засагаа бүс нутгийн зах зээлтэй холбох нь эдийн засгийн тогтолцоог боловсронгуй болгох төдийгүй, глобалчлалын сөрөг үр нөлөөг тарамдуулахад ч үр нөлөөтэй гэдэг утгаар, мөн түүнчлэн бүс нутгийн эдийн засгийн өсөлтийн үр өгөөжөөс хүртэхийн тулд Монгол Улс улам бүр өргөжиж байгаа АСЕАН-ы эдийн засгийн интеграцчлалд нэгдэх,

➤ АСЕАН-тай худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, АСЕАН-ы эдийн засгийн сүлжээнд орох нь олон улсын худалдааны яриа хэлэлцээнд манай улс ашиг сонирхлоо

хамгаалахад жин нөлөө үзүүлж болох юм. Хамтын ажиллагааны ийм суурь хөрс, олон улсын байгууллагуудын хүрээнд ч Монгол Улс өөрийн дэмжигч орнуудын бүлэгтэй болоход нааштайгаар нөлөөлөх,

➤ Мөргөлдөөнөөс зайлсхийх, аливаа асуудлыг яриа хэлэлцээний замаар шийдвэрлэх, хамтын ажиллагааг эрхэмлэсэн АСЕАН-ы аядуу, олон талт хандлага, зарчим Монгол Улсад хамтын ажиллагааг эрхэмлэсэн гадаад бодлого, үйл ажиллагааны туршлага бий болоход чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Зүүн Азийн хамтын нийгэмлэг бүрэлдэх явц нилээд шуударч буй энэ үед АСЕАН-ны гишүүн орнуудтай хоёр талын харилцаагаа бэхжүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр идэвхтэй ажиллах шаардлага тулгарч байна. Энэ хүрээнд АСЕАН-тай яриа хэлэлцээний түншлэлийн механизм бүрдүүлэх шаардлагатай байгаа бөгөөд уг асуудлыг Тайланд, Малайзын Гадаад хэргийн сайд нарын айлчлалын үеэр болон Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээний ээлжит хурлын үеэр холбогдох талуудад тавьж ажиллаа. 2007 онд АСЕАН-ы орнуудтай улс төрийн яриа хэлцээг идэвхжүүлэх, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд учирч буй саад бэрхшээлүүдийг багасгах, АПЕК-т элсэх нөхцөл бүрдүүлэх, бэлтгэл хийхэд анхаарч ажиллах зорилт тавин ажиллаж байна.²²

4. АСЕАН-тай хамтран ажиллах боломжит гарц Вьетнам мөн

Монгол Улс Зүүн Өмнөд Азийн орнуудтай харилцаатай ба зарим орнуудтай уламжлалт, найрсаг, ойр дотно харилцаатай явж ирсэн. Түүний нэг нь БНСВУ юм. Уламжлалт харилцааны хөрс суурийг бэхжүүлэхийн сацуу АСЕАН-ы бусад гишүүн орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, ялангуяа эдийн засаг, худалдааны салбарын харилцааг урагшлуулахад Монгол Улс анхаарч ажиллаж байна. Хэдийгээр АСЕАН-д нилээд сүүлд гишүүнчилсэн ч байгууллага дотроо чамгүй нэр хүндийг олж, богино хугацаанд өөрийн орны эдийн засгийг сайжруулж, бүс нутгийн байгууллагын шийдвэр гаргалтанд жин нөлөөтэй болж чадсан БНСВУ-ын дэмжлэг манайд маш чухал гэж үзэж байна.

1970-аад оны сүүлээр Камбожийн үндэсний ардын ардчилсан хувьсгал буюу Камбож дахь хэрэг явдлын мөн чанарыг Хятадын эрх баригчид мушгин гуйвуулсан суртал нэвтрүүлгийн өргөн компани дэгдээж байсан нь ЗХУ, БНСВУ-ын нэр хүндийг дэлхийн тавцанд бууруулахад чиглэгдэж байснаас гадна Вьетнамыг Зүүн Өмнөд Азийн бусад орнуудаас хөндийрүүлэх²³ гэх мэт зорилготой байсан бол одоо БНСВУ нь АСЕАН-ы гишүүд дотроо зөв бодлого явуулж улс орноо хөгжүүлж, тодорхой амжилтад хүрээд байгаа, нэр хүнд сайтай, нөлөөтэй орны нэг болж хэдийнээ чаджээ.

АСЕАН-ы гишүүн орнууд болон Ази, Номхон далайн бусад орнуудтай харилцах Вьетнамын харилцаа хөгжлийн эерэг хандлагуудыг харуулж байна. Эдгээрийн ихэнх нь АСЕАН-тай харилцах Вьетнамын олон талт харилцааны үр дүн юм.²⁴

АСЕАН дотор БНСВУ-ын үүрэг, жин нөлөө асар их бөгөөд үүнд дараахь шалтгаанууд нөлөөлсөн.

- Хүн ам ихтэй;
- Газар зүйн ашигтай байрлал. 3200 км далайн хил;
- Гадаад бодлогын үзэл баримтлалдаа тусгаар тогтнол, бие даасан байдлыг эрхэмлэдэг гадаад бодлого явуулна, ямар ч улсын дотоод хэрэгт оролцохгүй хэмээн заасан байдаг;
- АСЕАН дахь эв найрамдлын асуудлыг чухалчлан үздэг;

Вьетнам улс нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлийн эдийн засаг руу шилжихдээ томоохон дэвшлийг хийж чадсан. Тэр дундаа хоёр үнийн систем устаж, валютын ханш, инфляци тогтворжиж, барааны зах зээл дээрх өрсөлдөөн эрчимтэйгээр өссөн. Гол гол үйл явдлууд болсон 1989 оноос хойш бүтцийн шинэчлэл хийх, хууль боловсруулах, татвар бүрдүүлэх, улсаас татаас өгдөг асуудлыг зогсоох, үр ашигтай банкны системийг бий болгох, зах зээлийн эдийн засаг дахь Засгийн газрын үүрэг оролцоог дахин авч үзэх зэргээр чөлөөт зах зээлийг бий болгох ажлууд үргэлжилсэн байна.²⁵

Монгол Улс, БНСВУ хоёр НҮБ-д гишүүнээр элсэхэд нь бие биенээ дэмжиж байсан ба манай улс Вьетнамыг ДХБ болон НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Байнгын бус гишүүнээр сонгогдоход, манайхыг АРФ, АСЕМ-д элсэхэд Вьетнамын тал харилцан дэмжсэн билээ.

Манай улстай харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлж ирсэн байдал болон бүс нутгийн байгууллага дахь жин нөлөөг нь авч үзээд Монгол Улс АСЕАН-тай хамтран ажиллах боломжит гарц Вьетнам мөн юм гэж үзлээ.

Харин БНСВУ-ын хувьд Монгол Улс нь

- Түүхэн уламжлалт, найрсаг харилцаатай;
- Харилцан итгэдэг;
- Тус тусын сонгосон хөгжлийн замыг хүндэтгэн үздэг;
- Олон улсын тавцанд байнга бие биенээ харилцан дэмждэг зэрэг

шалтгаануудын улмаас АСЕАН-тай хамтран ажиллах боломжит гарц нь болоход бэлэн.

Хэрэв АСЕАН+3+1 гэсэн механизм бүрэлдэн бий болж энэ нь Монгол Улс байж чадсан тохиолдолд Монгол Улсыг БНХАУ, БНСУ, Япон улсын нэгэн адил үзэж харилцана гэдгээ Вьетнамын тал илэрхийлдэг билээ.

АСЕАН-ны гишүүн орнуудын ерөнхий үзүүлэлтүүд Хүснэгт №1

| | АСЕАН-о элсэн он* | Газар нутаг (км ²) | Хүн ам (млн) | ДНБ Үнэрбум ам.доллар | ДНБ-ий өсөлт | I хүрээ нэгдэх ДНБ GDP- per сарга (USD) | Инфляци | Хөрөнгө орруулах МДНБ | Амьдрах хүч (млн) | Экспорт Үнэрбум ам.доллар | Импорт Үнэрбум ам.доллар |
|------------------|----------------------|-----------------------------------|-----------------|-----------------------------|-----------------|---|---------|-----------------------------|----------------------|---------------------------------|--------------------------------|
| <i>Сингапур</i> | 1967 | 692,7 | 4,7 | 244 | 3.0% | 52900 | 1,6% | 27,0% | 2,8 | 349,5 | 307,6 |
| <i>Малайз</i> | 1967 | 329,750 | 25,3 | 397,5 | 5,5% | 15700 | 5,8% | 20,7% | 11,2 | 195,7 | 156,2 |
| <i>Филиппин*</i> | 1967 | 300,000 | 96,1 | 327,2 | 4,5% | 3400 | 9,6% | 16,2% | 36,8 | 51,0 | 63,4 |
| <i>Тайланд*</i> | 1967 | 513,000 | 65,5 | 570,1 | 4,8% | 8700 | 5,8% | 29,4% | 37,2 | 174,9 | 159,1 |
| <i>Индонези*</i> | 1967 | 1,891,000 | 237,5 | 932,1 | 5,9% | 3900 | 10,5% | 25,2% | 112,0 | 141,0 | 114,0 |
| <i>Бруней*</i> | 1984 | 5,800 | 0,4 | 20,6 | 0,6% | 54100 | 5,8% | 20,7% | 0,2 | 195,7 | 156,3 |
| <i>Вьетнам</i> | 1995 | 329,560 | 86,2 | 246,6 | 6,3% | 2900 | 24,5% | 44,5% | 47,4 | 63,7 | 79,3 |
| <i>Бирм*</i> | 1997 | 677,000 | 57,3 | 12,1 | 2,6% | 1800 | 21,4% | 11,8% | 28,5 | 3,6 | 2,1 |
| <i>Лаос*</i> | 1997 | 237,000 | 6,7 | 14,2 | 6,5% | 2100 | 8,5% | - | 2,1 | 1,1 | 1,2 |
| <i>Кампучи</i> | 1999 | 181,040 | 14,2 | 29,2 | 7,0% | 2100 | 21,1% | 21,3% | 7,0 | 4,6 | 6,4 |
| <i>АСЕАН*</i> | - | 4,465,500 | 593,9 | 2793,6 | 4,6% | 14760 | 11,4% | - | 285,0 | 1180,8 | 1045,6 |

www.cia.gov CIA fact book 2008 оны 07 сар

*www.aseansec.org ASEAN Statistic

Монгол ба АСЕАН-ны харилцаа, гадаад худалдаа /мянган ам.доллар/ Хүснэгт №2

| | МУ-тай дипломат харилцаа тогтоосон он* | Экспорт | | | | | | Импорт | | | | | |
|-----------------|--|---------------|-------------|--------------|-------------|---------------|-------------|---------------|-------------|---------------|-------------|---------------|-------------|
| | | 2006 I-XII | 2006 XII | 2007 I-IX | 2007 XII | 2008 I-XII | 2008 XII | 2006 I-XII | 2006 XII | 2007 I-XII | 2007 XII | 2008 I-XII | 2008 XII |
| АСЕАН | - | 2406.8 | 780.5 | 1236.7 | 548.6 | 2528.6 | 0.9 | 40587.7 | 4686.9 | 66926.8 | 11877.0 | 105290.5 | 10906.4 |
| <i>Вьетнам</i> | 1954 | 8.4 | - | 320.3 | 320.3 | 855.2 | - | 2961.6 | 110.6 | 6323.7 | 1474.9 | 9627.1 | 507.3 |
| <i>Индонези</i> | 1956 | 6.5 | - | - | - | 603.6 | - | 3879.7 | 283.5 | 3885.3 | 563.4 | 6829.3 | 819.8 |
| <i>Бирм</i> | 1956 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| <i>Кампучи</i> | 1960 | 28.6 | - | 259.0 | - | 357.8 | 0.9 | 4.2 | 0.3 | 24.1 | - | 20.4 | - |
| <i>Лаос</i> | 1962 | - | - | - | - | - | - | 0.7 | - | 0.6 | - | 1.5 | - |
| <i>Сингапур</i> | 1970 | 2321.0 | 778.4 | 437.6 | 11.1 | 363.7 | - | 20727.0 | 3097.1 | 29279.0 | 6489.8 | 44706.9 | 5343.1 |
| <i>Малайз</i> | 1971 | 42.2 | 2.1 | 3.0 | 0.4 | 1.9 | - | 9752.1 | 996.7 | 19808.6 | 2733.0 | 26082.3 | 2323.4 |
| <i>Филиппин</i> | 1973 | 0.1 | - | - | - | - | - | 1161.4 | - | 994.6 | 145.0 | 1135.7 | 79.6 |
| <i>Тайланд</i> | 1974 | - | - | 216.8 | 216.8 | 346.4 | - | 2101.0 | 198.7 | 6610.9 | 470.9 | 16887.3 | 1833.2 |
| <i>Бруней</i> | 1984 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |

*ГХЯ, Монгол Улсын гадаад бодлогын хөх ном, УБ, 2006 он

www.nso.mn Монголын Үндэсний Статистикийн Газрын

2007 оны эмхэтгэл

Монголын Үндэсний Статистикийн Газрын 2008

оны 12-р сарын бюллетинь

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Дүгэрсүрэн, М., Гомбосүрэн, Ц., *Монгол Улсын ХХ зууны гадаад бодлогын түүхэн тойм*, Улаанбаатар, 2004, 105-р тал.
2. *Монгол Улсын гадаад бодлогын Хөх ном*, Улаанбаатар, 2006, 64-р тал.
3. Батбаяр, Ц., “Ази, Номхон далайн хамтын нийгэмлэгийн дүр төлөв, түүнд Монголын эзлэх байр суурийн асуудал”, *Дорно-Өрнө*, 1994, №2, 42-р тал.
4. *Монгол Улсын гадаад бодлогын Хөх ном*, Улаанбаатар, 2006, 101-р тал.

5. Эрдэнэчулуун, Л., “Глобал ертөнц ба Монгол Улсын гадаад бодлого”, *Алтан аргамж*, 2001, №4, 15-р тал.
6. Цолмон, Д., “Даяаршил ба буурай хөгжилтэй орнуудын эрх ашиг, аюулгүй байдлын зарим асуудал”, *Олон улсын харилцаа*, Улаанбаатар, 2002, №2, 23-р тал.
7. Галсанжамц, С., “Ази, Номхон далайн аюулгүй байдлын хамтын ажиллагааны зөвлөл”, *Стратеги судлал*, Улаанбаатар, 1998, №1, 35-р тал.
8. Баярхүү, Д., “Монгол Улсаас ARF, ASEM, ACD-д оролцох бодлогын тухайд”, *Монгол, Вьетнамын харилцаа-50 жил*, Улаанбаатар, 2005, 70-р тал.
9. *Монгол Улсын гадаад бодлогын Хөх ном*, Улаанбаатар, 2006, 65-р тал.
10. Баярхүү, Д., “Монгол Улсаас ARF, ASEM, ACD-д оролцох бодлогын тухайд”, *Монгол, Вьетнамын харилцаа-50 жил*, Улаанбаатар, 2005, 73-р тал.
11. Бор, Ж., *Монголын Дипломат Товчоо*, Улаанбаатар, 2004, 207-р тал.
12. *Монгол Улсын гадаад бодлогын Хөх ном*, Улаанбаатар, 2006, 101-р тал.
13. Мөн тэнд, 26-р тал.
14. Баясах, Ж., “Монгол Улсын гуравдагч хөрш хийгээд түншийн асуудал”, *Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба гурав дахь түнш орнууд*, Улаанбаатар, 2002, 66-р тал.
15. Мөн тэнд, 69-р тал.
16. Мөн тэнд, 32-р тал.
17. <http://www.aseanregionalforum.org/>
18. <http://www.mfa.gov.mn>
19. Баясах, Ж., “Монгол Улсын гуравдагч хөрш хийгээд түншийн асуудал”, *Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба гурав дахь түнш орнууд*, Улаанбаатар, 2002, 65-р тал.
20. <http://www.mfa.gov.mn>
21. *ГХЯ-ны 2006 оны үйл ажиллагааны тайлан*, Гадаад харилцаа: Монгол Улсын ГХЯ-ны мэдээллийн товхимол, Улаанбаатар, 2(2007), 15-р тал.
22. Дашцэвэл, С., “Зүүн Өмнөд Ази дахь түгшүүртэй байдлын нэг голомт”, *Дорно дахины судлалын асуудал*, 1986, №1, 29-р тал.
23. Munkh-Ochir, D., *A constructivist view on identity and interest in foreign policy: Implications for Mongolia*, Ulaanbaatar, 2003, p.100.
24. Seiji Finch Naya, Joseph, L., H., Tan, *Asian Transitional Economies: Challenges and Prospects for Reform and Transformation*, California, 1995, p.99